

**ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 09 дүгээр сарын 21

№01

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн (1-203) өрөөнд 15:00 цагаас 95,7 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

**Хуралд:** Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Аюурзана, Б.Оюунтунгалаг, Д.Биндиряа, Л.Амартүвшин, Б.Батдэмбэрэл, Б.Мөнхцэнгэл, Я.Батцэцэг, Ш.Цоож, П.Ууганбаяр, Р.Мядагмаа, М.Дэлгэрмаа, Ц.Энхтуул, Г.Батцэцэг, Д.Ариунболор, Ч.Улам-Оргил, Д.Цэрэндолгор, Д.Дулмаа, Д.Батдорж, Г.Ариунтөгс нар оролцов.

**Үндсэн асуудал:**

1. Хөтөлбөрийн ерөнхий хорооны 2023-2024 оны хичээлийн жилийн ажлын төлөвлөгөө
  - ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү
2. Хууль, эрх зүйн баримтын (шинэчилсэн найруулга) сургалтын хөтөлбөртэй уялдах өөрчлөлт, түүнийг сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд тусгах
  - ХЕХ-ны нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа
3. Дээд боловсролын гүйцэтгэлийн үзүүлэлтэд суурилсан эрэмбэ, чансаа тогтоох ажлын хүрээнд хийгдэх дараагийн шатны Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ, Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд их дээд сургуулийн үзүүлж буй үр нөлөөллийг үнэлэх ажлыг ШУТИС-ийн хэмжээнд хэрхэн зохион байгуулж ажиллах
  - ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Хөтөлбөрийн ерөнхий хорооны хийх ажлын төлөвлөгөөг сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, түүнтэй уялдуулан сургалттай холбоотой журам шинэчлэх болон шинээр боловсруулах, сургалтын хувилбарт (цахим, танхим хосолсон, нэгдмэл агуулгатай хөтөлбөр, гадаад хэл дээр явуулах гэх.мэт) хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрт үнэлгээ хийх, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, төлөвлөх чиглэлд хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн оролцоог хангаж, ажиллах тул ХЕХ-ны гишүүдэд төлөвлөгөөний саналыг цахимаар хүргүүлэн, саналыг тусган, төлөвлөсөн ажилд гишүүдийг хуваарилан, батлахаар шийдвэрлэв.
2. Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан зүйл, заалт, БШУЯ-аас Дээд боловсролын онцлох ажил, 2023-2024 оны хичээлийн зорилго, зорилтыг ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд хэрхэн тусгаж, ажиллах шаардлагын талаар бүх багш нарын хэмжээнд мэдээлэл (цахим) хүргэхийг СХБА-ны дарга М.Эрдэнэтуяад даалгав.
3. Их, дээд сургуулийн эрэмбэ чансаа тогтоох ажлын хүрээнд дараагийн шатны бэлтгэл ажлыг хангаж ажиллах, ШУТИС-ийн хэмжээнд тодорхой зохион байгуулалт хийж, нэгдсэн дүнгээр мэдээллийг захиргааны газар, албад нэгтгэж, хянан БҮТ-ийн мэдээллийн нэгдсэн санд оруулна.
4. Бусад:
  - Боловсролын багц хууль шинэчлэл, хөтөлбөрт тавигдах шаардлагад нийцүүлэн “ШУТИС-ийн Бакалаврын цөм хөтөлбөрт тавигдах шаардлага”-д тодорхой өөрчлөлтийг оруулах.
  - Ахисан түвшний хөтөлбөрт тавигдах шалгуур, шаардлагыг дахин сайжруулан, хөтөлбөрийн ерөнхий хороонд хэлэлцүүлэх
  - Эрдэмтэн нарийн бичгийн дарга нар нь салбар, тэнхимийн боловсруулсан ахисан түвшний хөтөлбөрийг хөтөлбөр боловсруулах загварт нийцсэн, эсэхэд хяналт хийн, хөтөлбөрийн дэд хороонд хэлэлцүүлэх бөгөөд шаардлага хангасан ахисан түвшний хөтөлбөрийг хөтөлбөрийн ерөнхий хороонд хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.